



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.04.15-04.19

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд харьцангуй тогтвортой байлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг аж үйлдвэрийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол эрүүл мэнд болон даатгалын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

АНУ болон БНХАУ ирэх 5-р сарын эхэн гэхэд худалдааны хэлэлцээрт хүрэхийг зорьж байна. Улмаар АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп, БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпин нар 5-р сарын эцсээр хэлэлцээрээ баталгаажуулж, гарын үсэг зурах уулзалт хийнэ гэж эх сурвалж мэдээллээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп эдийн засгийн бололцоог хүн бүрт хүртээмжтэй байлгахад "Боломж бүс" хөтөлбөр санаачиллаа. Тэрээр Цагаан ордонд хийсэн мэдэгдлийнхээ үеэр "Америкийн иргэд бүгд хүчирхэг эдийн засгийнхаа шинэчлэлээс ашиг хүртэх хэрэгтэй" гэж онцолсон байна. АНУ-ын татвар бууруулах болон хөдөлмөрийн зах зээлийг дэмжих хуульд энэхүү "Боломж бүс" хөтөлбөр багтжээ. Улсын хэмжээнд хөрөнгө оруулалт татахад чиглэсэн энэ санаачилга нь АНУ-ын 50 мужийн 8,700 гаруй олон нийтийн төвийг хамруулж байна.

Европ: BREXIT хэлэлцээр 6 сараар хойшилж, АНУ болон БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээрт ахиц гарч байгаатай холбогдуулан Европын бүсийн STOXX Europe 600 индекс өсжээ.

Энэ долоо хоногт Европын хувьцаат компаниудын санхүүгийн тайлан гарч, тэдгээрийн ашигт ажиллагаа нэмэгдсэн байна.

Европын борлуулалтын менежерүүдийн индекс (PMI) буурч, тус бүс нутгийн эдийн засгийн өсөлт удааширч байгааг илтгэв. Тухайлбал, ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын PMI индекс 4 сар дараалан буурч, 44.5 нэгж болжээ. Харин Европын бүсийн хувьд тус үзүүлэлт бага зэргийн өсөлт үзүүлэн 47.8 нэгжид хүрчээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 1.5 орчим хувиар өслөө.

АНУ болон Японы эрх баригчид АНУ-ын Вашингтон хотноо уулзаж, худалдааны хэлэлцээр хийжээ. 3-р сард тус улсын АНУ-тай хийсэн гадаад худалдааны тэнцлийн ашиг 9.8 хувиар өссөн бол БНХАУ-ын талаас эрэлт буурч Япон улсын нийт экспорт 2.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Такси дуудлагын "Uber Technologies" компани автомат жолоодлогын нэгждээ "Softbank", "Toyota Motor", авто сэлбэгийн "Denso" компаниудаас нийт нэг тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт авахаар болсон байна. 2018 оны нэгдүгээр сард хийсэн найман тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтаараа "Softbank" нь "Uber Technologies"-ийн хувьцааны 16 хувийг эзэмшсэнээр хамгийн том хувьцаа эзэмшигч нь болж байв.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засаг шинжээчдийн таамаг хэмжээнээс илүү өндөр өсөлт үзүүллээ. 1-р улиралд тус улсын ДНБ 6.4 хувиар өсжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,881.95	-0.64% ▼
Dow Jones	АНУ	26,559.54	0.56% ▲
S&P 500	АНУ	2,905.03	-0.08% ▼
Nasdaq	АНУ	7,998.06	0.17% ▲
S&P/TSX	Канад	16,612.81	0.80% ▲
FTSE 100	Их Британи	7,459.88	0.31% ▲
S&P/ASX 200	Австрали	6,259.80	0.14% ▲
Nikkei 225	Япон	22,200.56	1.51% ▲
Hang Seng	Хонг Конг	29,963.26	0.18% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.03
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	99.16
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	98.96
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.65
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.05
DBM' 2023	USD	7.250%	102.79
TDBM' 2020	USD	9.375%	103.70

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.480	0.01 ▲
Libor 3M	2.580	-0.02 ▼
Libor 6M	2.630	-0.01 ▼
Libor 1YR	2.750	0.00 ▲
US 2YR Bond	2.376	-0.02 ▼
US 3YR Bond	2.346	-0.01 ▼
US 5YR Bond	2.376	0.00 ▲
US 10YR Bond	2.569	0.01 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.04.19	Өөрчлөлт
USD	2,635.94	0.16% ▲
CNY	393.17	0.37% ▲
EUR	2,963.72	-0.24% ▼
RUB	41.22	1.05% ▲
KRW	2.32	0.43% ▲
JPY	23.55	0.08% ▲
CAD	1,971.31	0.06% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,275.52	-1.16% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	15.03	0.39% ▲
Зэс	USD/lb.	292.65	-0.66% ▼
Нүүрс	USD/MT	87.13	0.00% -
WTI газрын тос	USD/bbl.	64.00	0.17% ▲
Brent газрын тос	USD/bbl.	71.97	0.59% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.49	-6.39% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. II	6.90%
Бодлогын хүү	2019. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. II	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. II	12.00%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. II	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. II	17.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. II	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 38 компанийн 467.7 сая төгрөгийн 2,876,551 ширхэг хувьцаа арилжигдав.


“Монгол шуудан” /MNP/ компанийн хувьцаа 12.28%-аар буюу хамгийн ихээр өсч 585.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” /JLT/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 131.75 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 130 ширхэг үнэт цаас 13.0 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.


4-р сарын 19-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,312.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,881.95 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.64%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	480.6
Зах зээлийн үнэлгээ	2,312,494.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,881.95	-0.64% ▼
MSE I индекс	8,778.22	-2.63% ▼
MSE II индекс	8,099.07	-1.07% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	262,601	155,758,187
ЛэндМН ББСБ	1,258,842	83,090,233
Говь	211,241	62,683,873
Түмэн шувуут	229,526	45,132,136
Ард кредит ББСБ	284,016	21,580,208

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол шуудан	585.00	12.28% ▲
Монгол савхи	570.00	11.76% ▲
Улсын их дэлгүүр	500.00	8.70% ▲
Багануур	1,190.00	7.50% ▲
Би Ди Сек	830.00	2.47% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	131.75	-15.00% ▼
Өндөрхаан	9,400.00	-14.86% ▼
МИК Холдинг	10,500.00	-8.70% ▼
Шарын гол	1,800.00	-7.93% ▼
Баянгол зочид буудал	27,000.00	-6.90% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт капитал	260,524,244
Би Ди Сек	120,125,685
Мирэ Эссет Секьюритис Монгол	94,041,172
Ти Ди Би Капитал	86,673,810
Ард Секьюритиз	79,412,114

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	584.36	621,865
Таван толгой	6,280.00	330,737
Говь	299.00	233,254
МИК	10,500.00	217,448
Сүү	211.34	72,701

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	130	12,992,200	99,940	99,940	156	15.140%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дютти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.05.01-ний дотор
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.01-с
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.12.31-ний дотор
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монос хүнс” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах мэдээлэл

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Монос Хүнс” ХК нь эрүүл мэндийн салбараас анх удаа олон нийтэд үнэт цаасаа санал болгож байгаа компани бөгөөд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх болон техник технологийг сайжруулах зорилгоор нийт хувьцааныхаа 30 хувь буюу 122,655,128 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 70 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 8.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Үнэт цаасны худалдан авах захиалгыг 2019 оны 4-р сарын 22-ноос 2019 оны 5-р сарын 03-ны өдрийн 10:00-17:00 цагийн хооронд Монголын хөрөнгийн биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авах юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК мэдэгдэл ирүүлээ

Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн (TSX:ERD | MSE:ERDN) нь Хөндий Алтны Төслийн 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг 2019 оны 4 сарын 12-нд “Сэндсторм Гоулд Лимитед” компаниас 1.2 сая канад доллараар худалдан авснаар тухайгаа зарлав. Энэ талаар “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ “Хөндий Алтны Төслийн Анхан Шатны Эдийн Засгийн Тооцооллын үр дүнд үндэслэн тооцоолоход 1%-ийн БЦАТ-ийн бодит үнэ цэнэ нь буцаан худалдан авах төлбөрөөс илүү байгаа тул БЦАТ-ийг буцаан худалдан авсанаар хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж бид үзэж байна. БЦАТ-ийг буцаан худалдан авснаар 2019 онд Хөндий Алтны Төслийн талбайд хийгдэх хайгуулын ажлын боломжит үр дүнгийн ач холбогдлыг нэмэгдүүлэх болно” гэж мэдэгдсэн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

МҮЦБ: “Мабу бонд” зохицуулалттай зах зээлд хаалттайгаар арилжих анхны бонд

Монголын Үнэт цаасны бирж биржийн бус зах зээлд арилжих “Мабу бонд”-ын төлбөр тооцоог гүйцэтгэх, төлбөрийн үүргийг тодорхойлохоор “Төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ”-г “Ковент ТМ” компанитай байгууллаа.

Ингэснээр “Мабу бонд” нь зохицуулалттай зах зээл дээр буюу Монголын Үнэт цаасны биржид хаалттай хүрээнд биржийн бус зах зээлээр арилжиж, төлбөр тооцоогоо мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой болж байгаа анхны бонд болж байна. Монголын Үнэт цаасны бирж төлбөр тооцоог хийснээр мэргэжлийн хөрөнгө оруулагчдын дунд арилжаа хийх, бондын эргэн төлөлт, хүүгийн урамшуулал зэргийг нэгдсэн зохион байгуулалтаар гүйцэтгэх боломжтой.

Үүнээс гадна хөрөнгө оруулагч болон компанийн хоорондын бондын арилжаа клирингийн байгууллагад давхар бүртгэгдэж баталгаажих, тухайн бондыг кастодиан банкаар хадгалуулан, хөрөнгө оруулагчийн нэр дээр эзэмшүүлэх зэрэг олон давуу талтай болж байгаа юм.

“Мабу бонд”-ын биржийн бус зах зээл дэх хэлцэл 4-р сарын 22-ноос эхлэн хийгдэнэ гэж Монголын Үнэт цаасны бирж мэдээллээ. 4-р сарын 26-ны өдрөөс эхлэн бирж үүнийг бүртгэн, төлбөр тооцоог нь гүйцэтгэхээр болжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МХБ I улиралд 49.2 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжсаны 90 хувь нь хувьцааны арилжаа байв

Монголын Хөрөнгийн бирж I улиралд нийт 49.2 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжсаны 90 хувь нь хувьцааны арилжаа байна.

Оны эхний улиралд хоёрдогч зах зээлд 29.1 тэрбум төгрөгийн хувьцаа, анхдагч зах зээлд 5.2 тэрбум төгрөгийн хувьцаа тус тус арилжигдсан байгаа юм.

Өнгөрсөн оны мөн үед Монголын Хөрөнгийн бирж 42 орчим тэрбум төгрөгийн үнэт цаас арилжиж байсан ч дийлэнх буюу 60 орчим хувь нь Засгийн газрын үнэт цаасны арилжаа байв. Харин энэ онд Засгийн газрын үнэт цаасны арилжаа нийт арилжааны 10 хүрэхгүй хувийг бүрдүүлсэн байна.

Мөн өнгөрсөн оны эхний улиралд “ЛэндМН ББСБ” компани IPO гаргаж, олон нийтээс 5 тэрбум төгрөг татан төвлөрүүлж байсан бол энэ онд “Түмэн шувуут” болон “Ард даатгал” компаниуд хөрөнгийн зах зээлээс нийт 15 тэрбум төгрөгийн санхүүжилт авч чаджээ. Цаашид хөрөнгийн зах зээлд хөл тавихаар зөвшөөрлөө хүлээж байгаа хэд хэдэн компани байгааг ойрын эх сурвалжууд мэдээлж байна. 4-р сарын 22-ны өдөр “Монос хүнс” компанийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа эхлэх билээ.

Хувьцааны хоёрдогч зах зээлийн дэлгэрүүлэн харвал, идэвхтэй арилжсан 20 компанийн хувьцааны арилжаа нийт арилжааны 98.9 хувийг бүрдүүлжээ. Өөрөөр хэлбэл, оны эхний улиралд хувьцааны хоёрдогч зах зээлд 29.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн ч “АПУ”, “ЛэндМН ББСБ”, “Хөвсгөл алтан дуулга” тэргүүтэй цөөн хэдэн компанийн арилжаа идэвхтэй байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ он гарснаас хойш 7.2 хувиар унаад байна

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ он гарснаас хойш 7.2 хувиар буурч, хоёр 2,362 тэрбум төгрөг боллоо. Үүнд хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 60 гаруй хувийг дангаараа бүрдүүлдэг дөрвөн том хувьцаат компанийн үнэлгээ 200 тэрбум төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч АПУ компанийн хувьцааны ханш он гарснаас хойш 7.8 хувиар унаад байгаа юм. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 54 тэрбум төгрөгөөр буурч, 633 тэрбум төгрөгөөр хэмжигдэх болов. Мөн “Тавантолгой” компанийн хувьцааны ханш энэ он гарсаар 12.4 хувиар унаж, зах зээлийн үнэлгээ нь 48 тэрбум төгрөгөөр буураад байгаа юм.


Дотоодын хөрөнгийн зах зээлд мэргэжлийн тоглогчид цөөн байгаа нь компаниудын үнэлгээнд сөргөөр нөлөөлдөг болохыг салбарын шинжээчид мэдээлж байсан юм. Өөрөөр хэлбэл, энэхүү зах зээлд эргэлдэх хөрөнгө хязгаарлагдмал байгаа нь компаниудыг бодит үнэлгээнд хүргэхэд саад болж байгааг онцолж байлаа.

Хамгийн сүүлд АПУ компанийн нэгж хувьцааг хөрөнгө оруулагчид 720 төгрөгөөр үнэлэн нийт хувьцааны 2.4 хувийг нь багцаар худалдан авсан байна. Харин тухайн үед хоёрдогч зах зээлийн хувьцааны ханш нь дунджаар 627 төгрөгөөр хэмжигдэж байжээ. Тиймээс цаашид хөрөнгийн зах зээлд гадны хөрөнгө оруулагчид болоод томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг оруулах нь зах зээлийн хөгжилд эеэгээр нөлөөлөх юм.

Үүний тулд төлбөр тооцооны “төлбөрийн эсрэг нийлүүлэлт” зарчимд суурилсан “Т+2” системийг нэн яаралтай нэвтрүүлэх шаардлагатай байгааг Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал илэрхийлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ҮСХ: I улиралд зэсийн баяжмалын экспорт 7 хувиар өсөж, 361.4 мянган тонн болов

2019 оны эхний улиралд зэсийн баяжмалын экспорт долоон хувиар өсөж, 361.4 мянган тонн болсон байна. Мөнгөн дүнгээр тооцвол 9 хувиар өсөж, 503.7 сая ам.доллар боллоо. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ-д нийлүүлсэн байна.

Гол экспортлогч “Оюу Толгой” ХХК-ийн тухайд уурхайн нөхцөл байдлаас хамаарч далд уурхайн бүтээн байгуулалтын ажил дахин сунжирч магадгүй гэж мэдээлсэн юм. Экспортын зах зээлээ төрөлжүүлэхээр Японд туршилтаар зэсийн баяжмал экспортолсон ч тэвээр, логистикийн асуудал бэрхшээл болж байгааг тус компанийн гүйцэтгэх захирал Армандо Торрес онцоллоо.

Харин жоншны экспорт биет хэмжээгээрээ 41 хувиар өсөж, 110.6 мянган тонн болсон бөгөөд мөнгөн дүнгээр 62 хувиар өсөж, 40.5 сая ам.доллар болсон байна. Жоншны экспортын 69 хувийг БНХАУ-д, 30 хувийг ОХУ, нэг хувийг БНСУ-д нийлүүлжээ. БНСУ-ын “Posco” компани Монголын жоншны салбарыг сонирхож байгаа бол Японы төлөөлөгчийн газар мөн байгуулагдсан байна. Цаашид “Хайлуур жоншны үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилтот хөтөлбөр”-ийг 2019-2024 онд хэрэгжүүлэхээр Засгийн газар ажиллаж байгаа юм. Хэдий тийм боловч жоншны нөөцийг нэгтгэн тогтоох, нөөцийн татварыг шийдвэр шаардлагатай гэж салбарынхан үзэж байна.

I улиралд цайрын экспорт 34 хувиар өсөж, 44 мянган тонн болжээ. Мөнгөн дүнгээр дөрвөн хувиар өсөж, 62.6 сая ам.доллар болжээ. Цайрын ханш Лондоны Металлын биржид өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.8 хувиар буурсан ч энэ он гарснаас хойш ханш нь эргэн сэргэж, 19 хувиар өсөөд байна. Нэг тонн цайрын фьючерс ханш 2,928 ам.доллар болжээ. Одоогоор цайрын экспортын 75 орчим хувийг “Цайрт минерал”, үлдсэнийг нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Шин шин” компани экспортолж байна.

Үүнээс гадна төмрийн хүдрийн экспорт биет хэмжээгээр 44 хувиар өсөж, хоёр сая тонн болжээ. Мөнгөн дүнгээр 66 хувиар өсөж, 106.5 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

TRQ: “Оюу Толгой”-ийн II босоо амны бүтээн байгуулалт X сард дуусах төлөвтэй

“Оюу Толгой”-ийн хөрөнгө оруулагч “Turquoise Hill Resources” компани гүний уурхайн II босоо амны бүтээн байгуулалтыг 2019 оны 10-р сард дуусгахаар төлөвлөж байгаагаа мэдэгдлээ.

Харин уурхайн нөхцөл байдлаас хамаарч гүний уурхайн бүтээн байгуулалт эцэслэж, анхны олборлолтоо эхлэх хугацааг 2021 оны III улирлаас хойшлуулж магадгүй байгаа юм. Энэ нь төсөлд ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг “Turquoise Hill Resources” судалж байгаа ажээ.

2019 онд “Оюу Толгой”-оос 125-155 мянган тонн зэс, 180-220 мянган унци алт бүхий баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа юм байна. I улиралд зэсийн гарц нь 18.2 хувиар өсөж, 45,800 тонн болсон бол алтны гарц нь 187.6 хувиар өсөж, 120 мянган унци болжээ.

Эдгээр мэдээлэлтэй зэрэгцээд Даваа гарагийн арилжаа хаагдах үед Торонтогийн Хөрөнгийн биржид “Turquoise Hill Resources”-ийн хувьцааны ханш 1.4 хувиар буурч, 2.13 канад доллар болжээ.

Үүний зэрэгцээ “Оюу Толгой” төслийн I болон II шатны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийх аудитын шалгалтыг хойшлуулсан байна.

Үүнээс гадна “Оюу Толгой”-ийн гол хөрөнгө оруулагч “Rio Tinto” групп I улирлын тайлангаа танилцууллаа. I улиралд “Rio Tinto”-ийн төмрийн хүдрийн нийлүүлэлт буурсан үзүүлэлттэй гарчээ. Тус компани I улиралд Австралиас 69.1 сая тонн төмрийн хүдэр нийлүүлсэн нь 2018 оны мөн үеэс 14 хувиар буурсан байна. Энэ нь шинжээчдийн хүлээлтээс тааруухан үзүүлэлт юм. Төмрийн хүдрийн нийлүүлэлтээрээ дэлхийд хоёрдугаарт бичигддэг тус компани 2019 онд нийт 333-343 сая тонн төмрийн хүдэр нийлүүлэхээр төлөвлөж байгаагаа зарлалаа. Энэ нь өмнөх төлөвлөгөө болох 338-350 сая тонноос бага дүн юм.

Өнгөрсөн онд “Rio Tinto” 338.2 сая тонныг нийлүүлсэн ажээ. Ийнхүү олборлолтоо бууруулж байгаа нь хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой аж. Тухайлбал, Австралийн баруун хойд эрэгт гуравдугаар сард “Veronica” далайн хар шуурга дайрч өнгөрсөн, мөн төмөр замын тэвээр саатсан зэргээс болж нийлүүлэлт тасалдсан байна.

Эдгээрээс гадна “Vale” компанийн далангийн осол зэргээс хамаарч цаашид нийлүүлэлт саарч, улмаар төмрийн хүдрийн ханш оны хоёрдугаар хагаст өсөх төлөвтэй байгаа юм. Иймд нийлүүлэлтийн хомсдолд салбар бэлэн биш байна гэж Шанхайн “Steelhome Information technology” компани таамагласан байна.

“Rio Tinto”-ийн хувьд төмрийн хүдрээс хэт хараат байдлаа багасгаж, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины цэнэг хураагуурын түүхий эдийг нэлээд сонирхож, хөрөнгө оруулалт хийж эхэлжээ. Зах зээлийг харвал өнгөрсөн нэг жилийн дотор “Rio Tinto”-ийн хувьцааны ханш 29 хувиар өссөн байна. Харин “Rio Tinto”-ийн гол өрсөлдөгч “BHP Group”-ийн хувьцааны ханш мөн хугацаанд гурван хувиар өсжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.